



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 4/52

Мандалговь

“Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд 12 хүний суудалтай автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Аймгийн ЗДТГ-ын албан хэрэгцээнд 12 хүний суудалтай автомашин” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Г.Самданцоодол (Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга)

Гишүүд: Э.Хөхөөхүү (Иргэний төлөөлөл)

С.Адъяасүрэн (Аймгийн Засаг Даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Б.Батхүү (Байгаль орчин аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын ХАА хариуцсан ахлах мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Г.Самданцоодол)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060201